



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 4/216

Мөрөн сум

Зарим ерөнхий боловсролын сургуулийн
нэршил өөрчлөх тухай.


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 30 дугаар зүйлийн 30.1.1, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/28 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Ерөнхий боловсролын сургуулийн нэршлийн загвар шинэчлэн батлах тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/28 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор нэр бүхий ерөнхий боловсролын сургуулиудын нэршлийг хавсралтаар шинэчлэн өөрчилсүгэй.

2.Нэр өөрчлөгдсөн ерөнхий боловсролын сургуулиудыг зөвлөгөө дэмжлэгээр хангаж, холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Отгон-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

	Одоогийн нэршил	Шинэчлэн өөрчилсөн нэршил
1	Ерөнхий боловсролын “Сод-Эрдэм” сургууль	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Сод-Эрдэм сургууль
2	Ерөнхий боловсролын “Авьяас” сургууль	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Авьяас сургууль
3	Ерөнхий боловсролын “Мөрөн Гурван-Эрдэнэ” сургууль	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Гурван-Эрдэнэ сургууль
4	Ерөнхий боловсролын “Дэлгэрмөрөн цогцолбор” сургууль	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Дэлгэрмөрөн сургууль
5	Ерөнхий боловсролын “Ирээдүй 21 дүгээр зуун” сургууль	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Ирээдүй сургууль
6	Ерөнхий боловсролын “Нутгийн Аваргууд” сургууль	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Нутгийн-Аваргууд сургууль
7	Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын лаборатори Эрдмийн далай цогцолбор сургууль	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Эрдмийн далай сургууль
8	Ерөнхий боловсролын “Титэм” сургууль	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Титэм сургууль
9	Хатгал тосгоны ерөнхий боловсролын сургууль	Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны ерөнхий боловсролын сургууль
10	Цэцэрлэг сумын Могойн гол багийн бага сургууль	Цэцэрлэг сумын Могойн гол багийн ерөнхий боловсролын сургууль
11	Бүрэнтогтох сумын Бүрэнхаан багийн цэцэрлэг-бага сургуулийн цогцолбор	Бүрэнтогтох сумын Бүрэнхаан багийн ерөнхий боловсролын сургууль
12	Галт сумын Зүрх багийн цэцэрлэг-бага сургуулийн цогцолбор	Галт сумын Зүрх багийн ерөнхий боловсролын сургууль